

ДҮРВЭГСДИЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА КОНТРАБАНДЫН ГЭМТ ЯВДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEMS ON LEGAL FRAMEWORK OF REGULATING REFUGEES AND CONTRABAND



В.ЖАВХЛАНЦОГТ ХСИС-ийн Хилийн сургуулийн захирал, цэргийн ухааны доктор, дэд хурандаа

JAVKHLANTSOGT V. Director of Border Institute, Law Enforcement University, Ph.D, lieutenant Colonel

Товч агуулга: Энэхүү өгүүлээр дүрвэгсдийн асуудлыг зохицуулах олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, сайжруулах болон контрабандын гэмт явдалтай тэмцэх талаар судлаачийн зүгээс дүгнэлт, санал дэвшүүлжээ.

Abstract: This article is to analyze and improve the coordination of international and national legal regulations for refugees and researcher's proposals on the fight against crime related to smuggling/contraband.

Хураангуй: Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад бий болсон шинжлэх ухаан, технологийн ололт нь нийгмийн бүхий л салбар дахь харилцааг тасралтгүй хувьсал, өөрчлөлтөд байлгаж, аливаа асуудлын нөлөөллийн хүрээг өргөжүүлэн тэлэхэд хүргэж байгаа билээ. Энэхүү үйл явц нь улс орны аюулгүй байдлыг хангах болон хууль сахиулах салбарт хүчтэй нөлөөлөл үзүүлж байна.

Дэлхий дахинд сүүлийн үед олонтаа тохиолдож байгаа нийтийг хамарсан гамшиг, осол, хүмүүнлэгийн хямралт байдлууд нь зөвхөн нэг улс орны хүрээнд байхаа болж, хөрш улсууд, бүс нутагт болон дэлхийн хамтын нийгэмлэгийн хүрээнд зохицуулалт шаардсан хэмжээнд хүрч даяаршиж байна. Үүний нэг хэлбэр бол “Дүрвэгсдийн хөдөлгөөн” юм. Ялангуяа гэнэт үүссэн аюул заналаас дайжсан хэдэн мянган хүн дүрвэн хөрш улсдаа урьдчилан тогтоогдоогүй нөхцөлд орж ирсэн үед амь нас аюулгүй байдлыг нь хангах, яаралтай тусламж үзүүлэх зорилгоор дүрвэгсдийн эрх бөөнөөр олгох асуудал олон улсын практикт байдаг бөгөөд үүнийг албан ёсоор “prima facie” зарчим гэж нэрлэн шийдвэрлэдэг.

1951 онд дүрвэгсдийн эрх зүйн байдлын тулгуур баримт бичиг батлагдан гарснаас хойш олон удаагийн туршлага сургамжаар баяжигдсаа эдүгээ дүрвэгсдийн асуудлыг зохицуулах арга, эрх зүйн орчин олон улсын хэмжээнд нэгэнт бүрэлдэн тогтсон байна.

Монгол Улсын аюулгүй байдлыг хангах салбарын үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг агуулсан эрх зүйн зарим актуудад Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын эрх зүйн үзэл санааны нийтлэг зарчмыг баримтлах, Эрүүгийн хуульд улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн дүрвэгчийн үйлдлийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг тодотгон хуульчилсан зэргээс нь харахад дүрвэгчдийн асуудлыг олон улсын эрх зүйн зарчимд нийцүүлэн зохицуулах боломж, хууль, эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрэлдсэн гэж үзэх боломжтой юм.

Гэвч “Монгол Улсын хилийн тухай хууль”, “Хил хамгаалалтын дүрэм” зэрэг Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээ бүхий эрх зүйн актуудад дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх асуудал харьцангуй тодорхой бус шийдлээ хүлээсэн хэвээр байна. Ялангуяа хөрш улсаас хил зөрчин олноороо дүрвэн орж ирж буй хүмүүст олон улсын дүрвэгчийн эрх зүйн “prima facie” зарчмыг баримтлан бөөнөөр дүрвэгсдийн эрх олгож буй тохиолдолд тэдгээрийн хувийн эд зүйлст хяналт шалгалт хийх, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон ба хязгаарласан бараа бүтээгдэхүүн, хар тамхи, мансууруулах бодис, галт зэвсэг зэргийг зөөвөрлөн авч яваа тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоо хараахан зохицуулагдаагүй байна.

Түлхүүр үг

1. НҮБ- Нэгдсэн Үндэстний Байгууллага
2. ДДКГ- Дүрвэгсдийн Асуудал Эрхэлсэн Дээд Комиссратын Газар
3. ДЭЗБТК- Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц

ОРШИЛ

Монгол Улс эрх зүйт ардчилсан нийгмийн тогтолцоог сонгон 1992 онд шинэ Үндсэн хуулийг батлан гаргаснаар олон улсын төвшинд харилцан итгэлцэл, хамтын ажиллагаанд тулгуурласан энхийг сахих, энхтайвнаар зэрэгцэн орших, улс хоорондын нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагаа, эрх зүйн орчныг хөгжүүлэх чиглэл дээр анхаарах болсон билээ.

Монгол улсын оршин буй бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил, хүн амын нягтрал, улс төрийн байгуулалтын шинж болон өнөөдөр нэгэнт гараад байгаа зарим нэг хурцадмал асуудал нь үй олон дүрвэгсдийг бий болгох магадлалтай гэж үзэхэд хүргэж байна. Энэ нь “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын үндсэн бүрдэл болох “Оршин тогтнохын аюулгүй байдал”-д сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлохдоо “Гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна.” [1.т.121] гэснээс харагдаж байгаа бөгөөд дүрвэгсэдтэй холбогдсон хямралт байдал бий болохоос урдчилан сэргийлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон заалт болсон байна.

Гэвч хөрш улсаас бөөнөөр орж ирсэн дүрвэгсэд нь “Монгол Улсын Эрүүгийн хууль”-ийн 175, 188-р зүйл хэсэгт хамаарах хориглосон ба хязгаарласан бараа бүтээгдэхүүн, эд зүйлс, хар тамхи, мансууруулах бодис, галт зэвсэг зэргийг зөөвөрлөн авч ирсэн тохиолдолд уг асуудлыг улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой эрх зүйн хэм хэмжээ, зохих туршлага, сургамж, хууль хяналтын байгууллагуудын ажиллагааны чиглэлээр тусгайлан судалгаа хийсэн байдал одоогоор үгүй байна.

1. ОЛОН УЛСЫН ДҮРВЭГСДИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хүн төрөлхтний түүхнээ олон дайн тулалдаан тасралтгүй үргэлжилж олон сая хүний амийг авч одсон билээ. Дайн тулааны үр дагавар зөвхөн сөргөлдөгч талуудын хоорондын тэмцлээр хязгаарлагдахгүй, олон сөрөг үр дагаврыг дагуулж байдаг бөгөөд түүний нэг нь байлдааны хөлөөс дайжин зугтаж яваа энгийн ард иргэд ихээхэн хэлмэгдэн зовдог асуудал

юм.

Олон улсын хэмжээнд хэнийг дүрвэгч гэж үзэх, ямар тусламж хамгаалалтыг үзүүлэх нь ихээхэн маргаантай асуудал байсан бөгөөд өнөөдөр ч онолын болон практикийн түвшинд аль алинд нь нэгдсэн ойлголт нэг мөр бий болж чадахгүй байсаар байна.

Дүрвэгчид ба тэднийг хамгаалах асуудал нэн эртний бөгөөд хүмүүс нийгэмшин амьдарч эхэлсэн тэр цаг үеэс үүдэлтэй түүхэн нийгмийн үзэгдлүүдийн нэг юм. 1950-аад онд дүрвэгсдийн талаарх нэгдсэн хэм хэмжээ бүхий эрх зүйн акт гарахаас өмнө дэлхийн улс орнуудад болон манай улсад дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэлтэй үймээн самуунаас дайжсан дүрвэгсэдтэй холбогдсон асуудал байсан. Жишээ нь Монгол улсын 8 дугаар их хурлын дараагаар коминтерний дарамт шахалтаар монголын хар шар феодалын хөрөнгийг хурааж, устгах, улс төрийн эрхийг хязгаарлах нэрийн дор олноор нь хэлмэгдүүлсэн нь баруун хязгаарын ард түмний дунд айдас түгшүүрийг бий болгосон бөгөөд үүнээс улбаалан Ховд аймгийн Алтай, Үенч, Булган, Мөнххайрхан, Дуут сумдын нутгаас нийт 1634 өрх айл дүрвэн гарсан байна. 1931 оны 12 дугаар сараас эхлэн Хятадын дотоодын улс төрийн тогтворгүй байдлаас үүссэн байлдаан үймээнээс дайжсан 2430 хасаг өрх нүүн орж ирсэн байдаг. [1.т.4]

XX дугаар зууны эхэн үеэс олон улсын эрх зүйн ухамсар төлөвшиж ирснээр дүрвэгсэдэд туслах хүчин чармайлт дэлхийн шинж чанартай болсон байна. Энэ нь дэлхийн хэмжээний том дайн болох болж түүнд олон улс татагдан орох болсонтой холбоотой.

Дэлхийн I дүгээр дайны дараа дүрвэгсдийн асуудлыг анх удаагаа олон улсын хэмжээнд гарган тавьж түүнийг зохицуулах арга замыг эрэлхийлж байсан нь 1921 онд “Үндэстнүүдийн нэгдэл”(nations union)-ээс Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн анхны Дээд Комиссарыг томилсон явдлаар харагдаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) үндэс суурь болсон энэхүү байгууллага нь дайнаас учирсан зовлон зүдгүүр, хохирол зэргийг харгалзан түүнийг арилгах, дахин дайн үүсэхгүй байх зорилгоор АНУ-ын ерөнхийлөгч Вудроу Уилсоны 14 нөхцөлт энхтайваны зарчимд дурдагдсан олон улсын байгууллага байгуулах саналыг үндэслэн дэлхийн I дүгээр дайны дараа байгуулагдсан. Уг байгууллага түүхийн богино хугацаанд буюу 1919 оноос 1946 оны хооронд оршин тогтносон хэдий ч 1933 онд Манжуурт явуулсан цэргийн ажиллагаанд нь Япон улсад сануулга өгсөн, 1937 онд Этиопт халдан довтолсон учраас Италийн эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ авсан, 1939 онд Финляндад халдан довтолсны дараа ЗХУ-хөөсөн зэрэг нь олон улсын хэмжээний асуудлыг шийдвэрлэхээр оролдлого явуулж байсны илрэл төдийгүй дэвшилтэд хэм хэмжээг агуулсан баримт бичгүүдийг гаргаж байснаараа анхдагч юм.

“Үндэстнүүдийн нэгдэл”-ээс дүрвэгсдийн талаар дараах баримт бичгүүдийг гаргаж байсан байна. Үүнд:

1. 1926 оны 5-р сарын 12-ны өдрийн хэлэлцээр
2. 1928 оны 6-р сарын 30-ны өдрийн хэлэлцээр
3. 1933 оны 10-р сарын 28-ны өдрийн конвенц
4. 1938 оны 2-р сарын 10-ны өдрийн конвенц
5. 1939 оны 9-р сарын 14-ны өдрийн протокол [2.т.13]тус тус болно.

Дээрх баримт бичгүүд нь дүрвэгсдийн талаарх асуудлуудыг шийдвэрлэх оролдлого хийгдэж байсны баримт мөн бөгөөд зарим талаар бага хүрээнд явцуу байдлаар асуудалд хандаж олон улсын нэгдсэн ойлголтонд хүргэж чадахгүй байсан юм.

Дэлхийн II дугаар дайн дууссаны дараа Европод 1 сая орчим дүрвэгсэд байгааг харгалзан тэдний асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1950 онд Дүрвэгсдийн Асуудал Эрхэлсэн Дээд Комиссратын Газрыг(ДДКГ) байгуулсан бөгөөд 1 жилийн дараа үйл ажиллагааны эрх зүйн гол үндэс болсон “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц”-ийг (ДЭЗБТК) НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1951 оны 7-р сарын 28-ны хурлаар батлан гаргасан байна. Энэхүү конвенц нь дүрвэгсдийн талаар гарсан хамгийн өргөн хүрээтэй хүчин төгөлдөр баримт бичиг болж чадсан ч агуулгын хувьд харьцангуй учир дутагдалтай болсон гэж үздэг. Энэ нь нэгдүгээрт конвенцийн нэгдүгээр зүйлийн 2 т...1951 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө болсон хэрэг явдлын үр дүнд...[2.т.13]гэсэн заалт нь дүрвэгсдийг бий болгосон нөхцөл байдлыг цаг хугацаагаар хязгаарласан, хоёрдугаарт конвенцийн нэгдүгээр зүйлийн 3 т...“Европод...болсон хэрэг явдал...Европод буюу бусад газар...болсон хэрэг явдал...[2.т.13]гэж заасан нь дүрвэгчид гэж тооцох эсэх асуудлыг газар зүйн байрлалаас хамааруулан хязгаарлалт хийх боломжтой байдал бий болгосон агуулгатай заалт батлагдсан зэрэг болох юм.

1967 оны 10 дугаар сарын 4нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдаанаар “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай” протоколыг батлан гаргаснаар 1951 оны конвенцын дээр дурдсан дутагдалтай асуудал шийдвэрлэгдсэн байна. Уг баримт бичгүүдэд дүрвэгчийг...арьс өнгө, шашин шүтлэг, үндэсний харьяалал, нийгмийн тодорхой бүлгийн харьяаллын болон улс төрийн үзэл бодлын улмаас мөрдөлт мөшгөлтөнд орно гэж үндэслэлтэйгээр айж харьяат орны гадна байгаа, хамгаалалтыг эдлэх боломжгүй, эдлэхээс хүсэхгүй байгаа хүн...[2.т.13] гэж заасан.

Дэлхийн өөр өөр бүс нутагт үүссэн дайн, зэвсэгт түрэмгийлэлтэй холбоотой дүрвэгсдийн өвөрмөц нөхцөл байдлууд нь асуудлыг шийдвэрлэх арга зам, үзэл баримтлалыг баяжуулан хөгжүүлж иржээ. Тухайлбал: Ази, Африкийн Хуулийн Зөвлөлдөх Хорооны 1966 онд Бангкок хотноо батлан гаргасан “Дүрвэгсдэд олгох нөхцөлтэй холбогдсон зарчмууд”,

Африкийн Нэгдлийн Байгууллагын 1969 онд батлан гаргасан “Африк тивийн дүрвэгсдийн өвөрмөц асуудлыг зохицуулах тухай Конвенц”, Төв Америкт үүссэн нөхцөл байдлыг зохицуулахаар 1984 онд батлан гаргасан “Дүрвэгсдийн Картагений Тунхаглал” зэргийг дурдаж болох бөгөөд дүрвэгсдийн тодорхойлолт дараах агуулгаар баяжигдсан байна. Үүнд:

1. Бангокийн нэгдсэн зарчимд ...эх нутаг нь гадны ямарваа нэг улсын түрэмгийлэлд өртсөн, эзлэгдсэн, гадны ноёрхол, нийгмийн хэв журмыг ноцтойгоор алдагдуулсан үйл явдал... [3.т.8]
2. Африк Тивийн Дүрвэгсдийн тухай Конвенцд ...оронд нь бүхэлдээ буюу аль нэг хэсэг нь нийтийн хэв журмыг ноцтой түйвээсэн гадны түрэмгийлэл, булаан эзлэлт, гадаадын ноёрхол буюу бусад хэрэг явдал тохиосны улмаас...[2 т.135]
3. Дүрвэгсдийн Картагений Тунхаглалд ...амь нас, аюулгүй байдал буюу эрх чөлөөнд нь түгээмэл хүчирхийлэл, гадны түрэмгийлэл, дотоодын мөргөлдөөн, хүний эрхийг хавтгайруулан хөсөрдүүлсэн хүчирхийлэл, нийгмийн хэв журмыг ноцтой алдагдуулсан бусад нөхцөл байдлын улмаас аюул занал нүүрлэсэн учир эх орноо орхин гарсан хүмүүсийг ...[2.т.157]

Дэлхийн аль ч улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орж ирсэн иргэдийн асуудлыг шийдвэрлэх үед баримтлах анхны зарчим нь “Буцаан шилжүүлэхгүй байх” юм. Энэ нь 1951 оны конвенцид...аль ч улс дүрвэгсдийг түүний амь нас буюу эрх чөлөөнд арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, нийгмийн тодорхой бүлгийн гишүүн буюу улс төрийн үзэл бодлын улмаас аюул занал нүүрлэсэн орны хил рүү албадан гаргах буюу буцаан шилжүүлж болохгүй...[4.т.17]гэсэн заалтыг үндэслэх бөгөөд бусад олон улсын гэрээ, конвенцууд буцаан шилжүүлэхийг шууд ба шууд бус байдлаар хориглодог.

НҮБ-ын ДДК-аас 2007 оны байдлаар нийт 21018589 дүрвэгч байгаагаас Ази тивд 7979251 буюу 37.9 хувь, Европ тивд 474039 буюу 22.5 хувь, Африк тивд 5069123 буюу 24.1 хувь, Америк тивд 3229822 буюу 15.3 хувь нь тус тус байрлаж байна. Монгол улс оршин буй Ази тив хамгийн их дүрвэгсэд бий болоод байгаа бүс нутаг болж байгаа нь илэрхий байна.

Европт үүсээд байсан дүрвэгсдийн асуудлыг зохицуулахаар анх байгуулагдсан НҮБ-ын ДДКГ нь 3 жилийн бүрэн эрхийн хугацаатай байсан бөгөөд түүнийг уул хугацааг дуусгаад татан буугдана гэж үздэг байсан ч өнөөдрийг хүртэл үргэлжлүүлэн ажилласаар байна.

Дүрвэгсдийн хямрал нь улам газар авч байгаа байдал нь 1950 оны үед Европт, 1960 оны үед Африкт дараа нь Азид бий болж байсан ба 1990 оны дунд үед эргээд Европт дахин гарч ирсэн давтамжаас

харагдаж байна.

Өнөөдрийн байдлаар дэлхийн 142 орон Дүрвэгсдийн эрх зүйн байдлын конвенц болон протоколд нэгдэн ороод байгаа бөгөөд манай улсын хоёр хөрш ОХУ, БНХАУ мөн нэгдэн орсон байна. Харин Монгол улс уг конвенц, протоколын алинд ч элсэн орж, нэгдээгүй.

Дүрвэгсэд бөөнөөр нэвтрэн орж ирсэн тохиолдолд НҮБ-ын ДДК-ийн үйл ажиллагааг дэмжих, орогнол олгогч улсын ачааллыг хуваалцах зорилгоор Дэлхийн хүнсний хөтөлбөр(WFP,НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF), Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага(WHO), НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDR), НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар (UNHCR), НҮБ-ын Хүмүүнлэгийн хэргийг Зохицуулах Газар (ОСНА), Олон Улсын Шилжин Суурьшилтын Байгууллага(IOM), Олон Улсын Улаан Загалмайн Хороо (ICRC), Улаан Загалмай Улаан Хавирган сар Нийгэмлэгүүдийн Холбоо (FRC) болон олон улсын хүмүүнлэгийн чиглэлийн Төрийн Бус Байгууллагуудтай харилцан ажилладаг систем бүрэлдэн тогтож олон улсад үйл ажиллагаагаа амжилттай явуулаад байна.

2. ДҮРВЭГСДИЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА КОНТРАБАНДЫН ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын шинж чанартай, эрх зүйн тулгуур баримт бичгүүдэд олон улсын эрх зүйн ерөнхий хэм хэмжээг хэрхэн хүлээн зөвшөөрч байгаа талаар дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

1. Монгол Улсын Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалын 3-ын 10-р зүйлд ... үндэсний аюулгүй байдлыг ... хууль зүйн аргаар... олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангана. [5.т.13] Мөн 23-ын 1-р зүйлд... олон улсын эрх зүйн түгээмэл зарчмуудыг сахих...2-р зүйлд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн НҮБ, олон улсын бусад байгууллагын үйл ажиллагааг дэмжиж нягт хамтран ажиллах... [5.т.15]
2. Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл баримтлалын 2-ын 8-р зүйлд Монгол Улс аливаа улстай харилцахдаа...НҮБ-ын дүрмэнд тодорхойлж нийтээр хүлээн зөвшөөрсөн болон олон улсын нийтлэг хэм хэмжээг удирдлага болгоно.[5.т.20] гэсэн заалт тус тус болно.

Дэлхийн нийтийн дүрвэгсдийн асуудлыг зохицуулж байсан туршлага сургамжаас харвал бөөнөөр дүрвэн яваа дүрвэгсэд улсын хилийн боомт, нэвтрэх эрх олгогдсон газраар зөвшөөрлийн дагуу нэвтрэн орж ирж байгаагүй ихэвчлэн шууд хил зөрчин орж ирж байсан байдал ажиглагдаж байгаа

бөгөөд энэ талаар Монгол Улсын Хилийн Тухай хуулийн 22-р зүйлийн 1д ...Монгол улсын олон улсын гэрээ, энэ хууль тогтоомжийн бусад акт, тэдгээртэй нийцүүлсэн эрх бүхий байгууллаас тогтоосон журам зөрчсөн үйлдлийг...уг зүйлийн 2т ... хилийн боомт бус газраар... эрхийн хүчин төгөлдөр баримт бичиггүйгээр ... нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан... [5.т.73] үйлдлүүдийг Монгол Улсын хилийг зөрчсөнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар хуульчилсан байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 89 дүгээр зүйл “Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх” гэмт хэрэгт оногдуулах хариуцлагыг хуульчлахдаа... Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн орогнох эрх олж авахын тулд хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ зүйл хамаарахгүй [6.т.136] гэж заасан нь хил зөрчигч дүрвэгч гэж тооцогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хэм хэмжээг тогтоосон байна.

Дээр дурдагдсан баримт бичгүүдийн агуулгад тусгагдсан заалтуудын үзэл санааг баримтлан Монгол Улсын хилээр нэвтрэн орж ирсэн дүрвэгсдийн асуудлыг 1951 оны Конвенц, 1967 оны Протоколын үзэл санаанд нийцүүлэн, олон улсын “буцаан шилжүүлэхгүй байх” зарчмыг баримтлан зохицуулалт хийх эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрэлдэн тогтсон гэж үзэх боломжтой юм.

Монгол Улсын Хил Хамгаалах Алба нь Монгол Улсын Үндсэн Хуулинд заасны дагуу улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүргийг хэрэгжүүлэх байгууллага бөгөөд дүрвэгчдийн асуудалтай анхлан тулгарах салбаруудын нэг юм. Гэтэл хилчдийн үйл ажиллагааны чиглэл болсон “Хил хамгаалалтын дүрэм”-д дүрвэгсдийн асуудал тодорхой тусгагдаагүй байна.

“Хил хамгаалалтын дүрэм”-ийн 9 дүгээр бүлэгт “Онцгой байдал”-ын үеийн хил хамгаалалтын үйл ажиллагааг тодорхойлсон. Онцгой байдлын үеийн хил хамгаалалт нь ... улсын хилийн зурвас, бүсэд... иргэд бөөнөөр хил нэвтрэхийг завдах,...зэвсэгт халдлага, түрэмгийлэл үйлдэгдэх нөхцөл байдал бий болсон үед...явуулах цогц үйл ажиллагаа... [7.т.65] гэж тодорхойлсон нь улс орон дайны байдалд тулж ирсэн, хөрш улс дотоодын дайн, зэвсэгт мөргөлдөөн, нийгмийн хямралт байдал бий болсон нөхцөлд онц байдлын үе гэж тодорхойлсон агуулгатай гэж үзэх үндэслэлтэй байна. Уг бүлгийн 194 дүгээр хэсэгт “иргэд бөөнөөр хил даван орж ирсэн үед хилийн отрядаас явуулах ажиллагаа” гэсэн сэдвийг оруулсан нь дүрвэгсдийн асуудлыг зохицуулах ажиллагааны нэг хувилбар гэж үзэж болох талтай. Гэвч дүрмийн агуулга нь хилээр нэвтрэн орж ирсэн бөөн иргэдийг дүрвэгч гэж үзэх эсэх талаар тодотгол байхгүй, мөн тодруулах талаар заалт тусгагдаагүй, хэрэгжүүлэх арга

хэмжээ нь цэргийн хүч хэрэгслээр буцаан гаргахад чиглэгдэж байгаа нь аюул занал нүүрлэсэн орны хил рүү албадан гаргах буюу буцаан шилжүүлэхгүй байх олон улсын дүрвэгсдийн талаар баримтлах нийтлэг зарчимтай зөрчилдөж байгаа юм.

Зэвсэгт Хүчний “Байлдааны дүрэм 200”-ийн (түр) “Улсын хил хамгаалалтанд оролцох” гэсэн 12-р бүлэгт зэвсэгт хүчний анги салбарыг хил хамгаалалтанд оролцох үндэслэлийг... цагийн байдал хурцадсан үед... мотобуудлагын батальон хүртэл хүчийг улсын хил хамгаалалтанд үүрэг гүйцэтгүүлж болно... [8.т.442] гэж заасан байна.

Дүрмийн 1210-р зүйлд цагийн байдал хурцадсан үеийг ... гадаадаас зэвсэггүй иргэд бөөнөөр улсын хилд цөмрөн орж ирж өдөөн хатгалга үйлдсэн... улсын хилийг дүрвэгсэд зөрчин орж ирсэн буюу гарахыг завдсан ажиллагаануудыг хэлнэ... [8.т.442] дүрмийн 1230-р зүйлд ... дүрвэгсдийг тогтоох хилийн хорооны ажиллагаанд батальон /рот/ нь дүрвэгсдийн лагерь байгуулах, түүнийг хамгаалах, ... олон улсын болон өөрийн улсын энэрэнгүй байгууллагуудтай хамтран тэдгээрт эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, хүнсний хангалт хийх, орон сууцаар хангах, тээвэрлэх зэрэг ажиллагаанд оролцож болно... [8.т.447] гэж заасан нь дүрвэгсдийн талаар харьцангуй тодорхой тусгасан байна гэж үзэж болох бөгөөд ялангуяа харилцан ажиллах байгууллагууд, ажиллагааны төрлүүдийг зааж өгсөн нь нэлээд дэвшилтэт хэм хэмжээ бүхий заалт болсон байна. Мөн дүрмийн 1231-р зүйлд Монгол Улсын Засгийн Газраас дүрвэгсдийг хүлээн авахгүй гэсэн шийдвэр гаргасан тохиолд тэдгээрийг нутгаасаа түлхэн гаргах ажиллагааг зэвсэггүй бөөн иргэдийн өдөөн хатгалгыг таслан зогсоох ажиллагааны арга тактикаар явуулна [8.т.447] гэж заасан нь учир дутагдал бүхий агуулгатай болсон байна.

Дээрх эрх зүйн актуудын холбогдох заалтууд нь Монгол Улсын аюулгүй байдлыг хангах салбарын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон хэм хэмжээг харилцан зөрчилтэй байдалд хүргэж байгаа юм. Гэтэл Монгол Улс нь дэлхийн харьцангуй тогтворгүй хэсэг болох Зүүн хойд Ази тивийн хэсэгт оршиж буй бөгөөд уг бүс нутагт цэргийн уламжлалт аюул, заналаас гадна хүний амьдрах орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг агаарын дулаарал, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, цагаачлал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх гэх мэт улс орнуудын хилийн шугамаар хязгаарлагдахгүй олон төрлийн уламжлалт бус шинэ аюулын заналхийлал, гэмт явдлуудын хэлбэрүүд үүсэн бий болж улмаар тасралтгүй өргөжин тэлж байгаа нь улсын хил зөрчин бөөнөөр орж ирж болзошгүй дүрвэгсдийн урсгалыг бий болгож болох бодит хүчин зүйлс болж байгаа юм.

Гэнэт бий болсон олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдсон бодит аюул заналын улмаас улсын хилээр олноор нэвтрэн орж ирсэн дүрвэгсдийн асуудлыг хилийн бүс нутагт шийдвэрлэх ажиллагаа нь батлан хамгаалах болон Үндэсний аюулгүй байдалтай шууд холбогдож байна. Тиймээс Монгол Улс нь дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үзэл баримтлал, олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй шууд зөрчилдөхгүй байдлаар “*prima facie*” зарчмыг хэрэглэж, олон тооны дүрвэгсдэд “түр хамгаалалт”-ыг олгохоос өөр аргагүй байдалд хүрч болох юм. Энэ тохиолдолд олон тооны дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд хүн болгонд тусгайлан шалгалт хийх нь цаг хугацааны хувьд боломжгүй байдаг.

Дүрвэгсэд нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 175-р зүйлд заагдсан Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг “Хориглосон ба хязгаарласан”, “Их хэмжээний валют”, “Валютын үнэт зүйл”, “Эрдэнэс”, “Эрдэс”, “Байгалийн төрц”, “Түүх соёлын дурсгалт зүйлс”, “Музейн үзмэр”, “Эртний амьтан, ургамал”, “Үнэт олдвор, эд өлгийн зүйлс” зэргийг мөн 188-р зүйлд заагдсан “Галт зэвсэг”, “Байлдааны галт хэрэглэл”, “Хар тамхи”, “Мансууруулах бодис”, “Хордуулах бодис”, “Цацраг идэвхт бодис”, “Тэсэрч дэлбэрэх бодис” зэрэг хуулиар заагдсан халдлагын зүйлсийг биедээ авч явах тохиолдол нь дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх олон улсын практикт олонтой тохиолдож байсан байна.

Дүрвэгсдийн авч яваа Монгол Улсын Эрүүгийн хуулийн 175-р зүйлд заасан улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон зарим эд зүйлс нь дараах байдлаар хэлбэр, хэмжээ, физик химийн шинж, үнэ ханш зэрэг шинж чанараараа тухайн төрлийн гэмт хэргийн халдлагын зүйл болж байдаг онцлогтой байна.

Үүнд:

- “Хориглосон ба хязгаарласан” эд зүйлст Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэр улсын хилээр гаргах ба оруулах, эсвэл зөвхөн оруулах, гаргахыг түүнчлэн дамжин өнгөрүүлэхийг хориглосон бараа, түүхий эд, эд зүйлсийг хамруулдаг. Өнөөдөр уг эд зүйлсийг Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 51-р тогтоолоор “Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодолсон жагсаалт”-аар тодорхойлсон.
- “Эрдэнэс”-т “...түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг ямар ч байдалд байгаа үнэт мателл, эрдэнийн чулуу...”-г [11.т.35] ойлгох бөгөөд Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3-р зүйлд тодорхойлсон
- “Түүх, соёлын дурсгалт зүйлс”-т түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол

бүхий эд өлгийн зүйлсийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хамааруулдаг байна.

Дүрвэгсдийн амь нас, эрүүл мэнд, эрх эрх чөлөөнд занал хийлсэн аюул нь тухайн үнэт ховор, өөрийн болон гэр бүлийн өмч хөрөнгө, түүхэн дурсгалт эд зүйлсийг хамгаалах зорилгоор Монгол Улсын Эрүүгийн хуулийн 175-р зүйлээр тодорхойлогдсон эд зүйлсийг бие дээ авч явах бодит шаардлагыг бий болгох бөгөөд энэ нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын үндсэн шинж болох "... зохих зөвшөөрөлгүй гаалийн үзлэгийн гадуур, хилийн боомт бус газраар эсвэл гаалийн үзлэгээс нуун далдлах тухайн эд зүйлийн нэр, төрөл, тоо хэмжээ, хэлбэр дүрс баглаа боодлыг өөрчлөх, ...гаалийн мэдүүлэгт бичихгүй орхих...зэрэг аргаар улсын хилээр эсвэл гаалийн хяналтын талбайн хилээр ... оруулсан, дамжин өнгөрүүлсэн..." [11.т.39] бүрдүүлсэн байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 188-р зүйлд заасан "Галт зэвсэг", "Байлдааны галт хэрэглэл"-ийг дүрвэгсэд нь өөрийн болон гэр бүлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор авч явах, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 3-р сарын 14-ний өдрийн 54-р тогтоолын 1-р хавсралтад заагдаж хориглогдсон нэр төрлийн "Хар тамхи, мансууруулах бодис"-ыг тухайн улсад зөвшөөрөгдсөн тун хэмжээгээр эмчилгээний журмаар, өвчин намдаах зорилгоор авч яван улсын хил нэвтрэх үзэгдэл нь олонтой тохиолдож байсан байна.

Гэвч Монгол Улсын Эрүүгийн хуулийн 175-р зүйлд хамааруулах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын зайлшгүй байх шинж болох гэм буруугийн шууд санаатай хэлбэр нь "...тухайн үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлан түүнээс ... учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдаас мэдсээр байсан ч зориудаар хүсэж бий болгох..."-оор тодорхойлогдсон ч дүрвэгсдийн үүсэж бий болсон бодитой аюул заналын улмаас аргагүйн эрхэнд хийсэн шилжилт хөдөлгөөний улмаас улсын хил нэвтрэн дээрх эд зүйлсийг авч ирэх, "Хар тамхи, мансууруулах бодис"-ийн төрлийн бэлдмэлийн төрлийг манай улсад хориглогдсон ч тухайн улсад зөвшөөрөгдсөн тун хэмжээгээр эмчилгээний журмаар, өвчин намдаах зорилгоор хэрэглэхээр авч явах тохиолдлууд нь гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талыг үгүйсгэж байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл дүрвэгсдэд хориглосон ба хязгаарлсан эд зүйлсийг дээрх байдлаар улсын хил нэвтрэн орж ирэхдээ авч ирсэн тохиолдлыг гэмт хэрэгт тооцохгүй байх үндэслэлтэй юм.

Гэвч гэмт явдал улс орны хүрээнээс хальж бүс нутаг, дэлхийн нийтийн хэмжээнд даяаршиж, нарийн зохион байгуулалтай болж буй байдал нь Дүрвэгсдийн шилжилт хөдөлгөөний онцлог, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд тавих улс орнуудын хяналт, шалгалтын хөнгөлттэй байдал, уг үйл

ажиллагааны цаг хугацааны хувьд хязгаарлагдмал нөхцөлд өргөн орон зайд явагдах шинж чанарыг зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон эд зүйлс, хар тамхи, мансууруулах бодисын тээвэрлэлтээ өнгөлөн далдлах байдлаар ашиглах нөхцлийг бүрдүүлж болзошгүй юм.

ДҮГНЭЛТ

Дүрвэгсдийн эрх зүйн орчин олон улсын түвшинд бүрэлдэн тогтсон хэдий ч хөгжингүй орнуудад дүрвэгсдийн эрх зүйн баталгааг олж авах цагаачдын оролдлого идэвхтэй явагдаж байгаа нь дүрвэгсдийн асуудлыг зохицуулахад бий болж болзошгүй шинэ бэрхшээлт хандлага байж болох юм.

Дүрвэгсдийн Конвенцид Монгол Улс элсэн ороогүй байгаа нь Засгийн Газар дүрвэгсдийг хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргах эрхтэй гэж үзэж үндэслэл байж болох юм.

Монгол Улсын Төрийн болон Батлан Хамгаалах үзэл санааны тулгуур баримт бичгүүдэд дүрвэгсдийн асуудлыг НҮБ-ын ба олон улсын нийтлэг зарчимд тулгуурлан шийдвэрлэх чиглэлийг заасан хэм хэмжээ тусгагдсан гэж үзэж болох юм.

Дүрвэгсэд нь аюул заналаас дайжин аргагүй эрхэнд улсын хил зөрчин орж ирсэн болон хязгаарласан ба хориглосон бараа бүтээгдэхүүнийг авч ирсэн зарим үйлдэл гэмт хэрэгт тооцогдохгүй байх боломжтой байдлыг ашиглаж үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл нь дүрвэгсэд ба хүмүүнлэгийн үйл ажиллагааг мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах үйлдэлд ашиглаж болзошгүй юм.

Тиймээс холбогдох хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, улмаар дүрвэгсдийн асуудлыг зохицуулахад хүчний болон хууль хяналтын байгууллагуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг, арга тактик, Монгол дахь НҮБ-ын ДДК-ын төлөөлөгч, олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай харилцан ажиллах чиглэлийн талаар тусгайлсан судалгааг явуулах шаардлагатай байна.

ЭШЛЭЛ АВСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

www.nsc.gov.mn/интернет веб:/

Баруун хязгаарт болсон хэрэг явдлын тухай./Эх орны манаа.Сонин.УБ.2008.05.№06/

Дүрвэгсдийн асуудлаарх олон улсын эрх зүйн үндсэн баримт бичгүүд.НҮБ.ДДК.УБ.2002.-350х;

Дүрвэгсэд./ДАЭДК.сэтгүүл.УБ.2001.№2/

Дүрвэгсдийн талаарх олон улсын лавлах. ОУПХ,НҮБ ДАЭДК.УБ. 2007.№2.-138х;

Монгол Улсын Зэвсэгт Хүчний эрх зүйн үндэс.